

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГААС ЗАРЛАЖ
БУЙ НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН ЕРӨНХИЙ БОЛОН
ТУСГАЙ ШААРДЛАГЫН ТАЛААР**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан “2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу www.tender.gov.mn цахим хуудсаар дамжуулан нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллаж байна.

2025 оны Худалдан авах ажиллагаанд тусгагдсан худалдан авах ажиллагаанд дараах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтийг тавьж сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан шалгана.

2. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.

3. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. Жич: Дээрх 2 лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.

4. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 70 хувиас багагүй байх. Байгууллагын дансны үлдэгдэл (Харилцагч банк тус бүрийн дансны үлдэгдлийг ирүүлнэ.) Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолтыг тус тус ирүүлэх ба нийлбэр дүнгээр нь тооцно.

5. 2023, 2024 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.ebalance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг үнэлгээнд харгалзах ба төсөвт өртгийн 70 хувиас дээш борлуулалтын орлоготой байхыг шаардана.

6. Урьд өмнө нь ижил төстэй гэрээний хэрэгжүүлсэн туршлагатай байх ба төсөвт өртгийн 70 хувиас дээш байхыг шаардана.

Холбогдох худалдан авах ажиллагааны жагсаалтыг www.tender.gov.mn цахим хуудсаар дамжуулан танилцана уу.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР